БАТЛАВ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.МӨНГӨНХУЯГ

"НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ БАГЦ-7" АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 03 дугаар сарын 07 Дугаар А/45 Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1 | Ажлын даалгавар боловсруулах үндэслэл | - Монгол улсын Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоол<br>- Нийслэлийн Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22 дугаар тогтоол,<br>- Баянгол дүүргийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/86 дугаар захирамж |
| 2 | Захиалагч байгууллага | Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| 3 | Байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ | Хавсралтаас харах |
| 4 | Ерөнхий шаардлага | Төр хувийн хэвшлийн түншлэлийг хангах, дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний менежментийг сайжруулах |
| 5 | Зориулалт хүчин чадал | Нийтийн эзэмшлийн 5.16 км 79,940 м2 гудамж, зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ хийх, тээвэрлэх, халтиргаа гулгааг арилгах, |
| 6 | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээний шаардлага | 1 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хаиуцан ажиллах зам талбайн бригад, зам талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг тээвэрлэх, халтиргаа гулгаа арилгах, угаалга цэвэрлэгээ хийх ажлыг гүйцэтгэнэ.<br>2 Дүүргийн Засаг даргын Тамгын газраас өгсөн цаг үеийн шинжтэй шуурхай үүрэг чиглэлийг тогтмол биелүүлж ажиллана.<br>3 Зам талбайн цэвэрлэгээний ажлыг Засаг даргын Тамгын газар, гэрээт хөндлөнгийн хяналтын Төрийн бус байгууллагууд өдөр бүр хянаж, сар бүр шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгнө.<br>4 Үнэлгээг хариуцсан гудамж бүрээр үнэлэх ба 80 буюу түүнээс доош үнэлгээг 2 удаа авсан тохиолдолд тухайн гудамжийг гэрээнд заасан тоо хэмжээнээс хасаж, гэрээнд өөрчлөлт оруулна.<br>5 Хариуцсан гудамж зам дагуух аж ахуйн нэгж, байгууллагад орчны 50 хүртэлх метр нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх талаарх эрх зүйн шийдвэрийг сурталчлах, шаардлага тавьж ажиллана.<br>6 Халтиргаа гулгаа арилгах давс, бодис, хайрга зэргийг хариуцсан зам талбайн хэмжээнд тооцоолон нөөцлөх<br>7 Зам талбайн цэвэрлэгээний график, маршрутыг жил, улирал, сараар гаргаж ажиллана.<br>8 Зам талбайн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг ачиж тээвэрлэх үйл ажиллагаанд ажиллах машин техник нь газар зүйн мэдээллийн (GPS) систем бүхий тоног төхөөрөмжтэй байх ба нийслэлийн хог хаягдлын менежментийн хяналт, удирдлагын нэгдсэн цахим системд холбогдох боломжтой байх<br>9 Зам талбайн цэвэрлэгээнд ашиглах автомашин нь стандарт шаардлага хангаж, тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоонд хамрагдсан, байгаль орчин, агаарын чанарт сөрөг нөлөөгүй байх<br>10 Зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг гүйцэтгэн ажиллахдаа хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, |

| | | |
|---|---|---|
| | | багаж хэрэгслийг бүрэн бүрдүүлж ажиллана. (хамгаалалтын малгай, хогны тэрэг, тумба, цацруулагч, байгууллагын лого, ажилтны нэр бүхий өвөл зуны ажлын хувцас, бээлий, маск, хамгаалалттай ажлын гутал, хамгаалалтын нүдний шил, хүрз, цас цохигч цохиур, шүүр г.м)<br>11 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байсан бол давуу тал болно. |
| 7 | Ажил гүйцэтгэхэд ашиглах материал | <u>Хууль, тогтоомжууд</u><br>- Хог хаягдлын тухай хууль.<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль<br>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02 дугээр сарын 20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолоор батлагдсан "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам<br>- Бусад холбогдох стандарт норм дүрэм, журмыг баримтлах. |
| 8 | Нэмэлт | Багцын нийт дүнд Захиалагчийн хяналтын 2% багтсан болно. |
| 9 | Эдийн засгийн тооцоо, төсөв | Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох. |

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Г.ЭНХЦЭНГЭЛ

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Г.МӨНХ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АГААРЫН БОХИРДОЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Ө.БАТЧУЛУУН

"НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ БАГЦ-7" АЖЛЫН ХАВСРАЛТ

2025.03.07 Улаанбаатар хот

| № | Гудамж, талбайн нэршил | Авто замын урт,км | Өргөн, м | Талбай, м.кв | Тариф /₮/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Ажилчны гудамж | 1.7 | 21 | 35,700 | 70 |
| 2 | ТЭЦ-3 шинэ зам | 0.66 | 14 | 9,240 | 70 |
| 3 | Эрчим хүчний гудамж | 2.1 | 14 | 29,400 | 70 |
| 4 | Гурвалжин доод тал | 0.7 | 8 | 5,600 | 70 |
| Нийт | | 5.16 | | 79,940 | |